



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 21 өдөр

Дугаар А/КЗ/1

Хэрлэн сум

**Хүндэтгэл үзүүлж,  
хөрөнгө зарцуулах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Аж Үйлдвэрийн Гавьяат ажилтан Жагдагийн Оюунбаатар, аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга хурандаа Намсрайн Хүрэлээ нарт хүндэтгэл үзүүлэхэд зориулж 2,360,000 (хоёр сая гурван зуун жаран мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх арга хэмжээний зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөх боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны  
дугаар сарын 21-ны өдрийн  
дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

№	Нэр	Нэгжийн үнэ	Тоо хэмжээ	Мөнгөн дүн
1	Хүндэтгэл	1,100,000	1 ш	1,100,000
2	Мөнгөн аяга	330,000	3 ш	990,000
2	Өргөмжлөл	60,000	4 ш	240,000
3	Батламж	15,000	2 ш	30,000
	Нийт дүн			2,360,000